



**Харилцаа холбооны зохицуулах хорооны
2023 оны ээлжит бус 01 дүгээр хуралдааны
мэдээлэл**

Монгол Улсын Харилцаа холбооны зохицуулах хорооны 2023 оны ээлжит бус 01 дүгээр хуралдаан 2023 оны 03 дугаар сарын 17-ны өдөр болов.

Харилцаа холбооны тухай хуулийн 8.3, 8.4-т заасныг тус тус үндэслэн Монгол Улсын Ерөнхий Сайдын 2023 оны 03 дугаар сарын 01-ны өдрийн “Орон тооны бус гишүүн томилох тухай” 36 тоот захирамжаар Нямдалай овогтой Мандахбаатарыг Харилцаа холбооны зохицуулах хорооны орон тооны бус гишүүнээр 2 жилийн хугацаагаар томилов.

Зохицуулах хорооны 2023 оны ээлжит бус 01 дүгээр хуралдаанаар “Үндэсний радио давтамжийн хуваарилалтын хүснэгт”-д нэмэлт, өөрчлөлт оруулах саналын тухай; Тусгай зөвшөөрлийн тухай (ТЗ шинээр олгох, сэргээх, сунгах, түдгэлзүүлэх, хүчингүй болгох тухай) тухай зэрэг асуудлыг хэлэлцэн хорооны хуралдааны 5 тогтоолыг батлан шийдвэрлэсэн.

Тус хуралдаанаар Зөвшөөрлийн тухай хууль болон уг хуулийг дагалдан 2023 оны 01 дүгээр сарын 06-ны өдөр Радио долгионы тухай хуульд Үндэсний радио давтамжийн хүснэгтэд оруулсан холбогдох нэмэлт, өөрчлөлтүүд, бусад хууль тогтоомжтой нийцүүлэн ХХЗХ-ны ажлын албанаас боловсруулсан “Үндэсний радио давтамжийн хуваарилалтын хүснэгт”-д нэмэлт, өөрчлөлт оруулах Хорооны саналын тухай танилцуулгыг сонсож, хорооны дарга болон гишүүдээс зарчмын зөрүүтэй санал гараагүй тул энэхүү хүснэгтэд оруулах нэмэлт, өөрчлөлт оруулах саналыг хариуцсан бүтцийн нэгж болох РДЗХГ, Хуулийн хэлтсээс эцсийн найруулга, редакцыг хянаж, Хорооны удирдлагад танилцуулан Цахим хөгжил, харилцаа холбооны яаманд албан тоотоор хүргүүлэх нь зүйтэй гэж тогтов. Үндэсний радио давтамжийн хүснэгт нь радио давтамжийн 8.3кГц-300ГГц-ийн зурвас буюу Радио долгионыг Дэлхийн радио холбооны дүрэмд нийцүүлэн утасгүй холбооны техник, технологийн хөгжлийн чиг хандлага, үндэсний аюулгүй байдал, өөрийн орны онцлог, ашиг сонирхолтой уялдуулан боловсруулсан төлөвлөгөө юм.

Зохицуулах хорооны 2023 оны ээлжит бус 01 дүгээр хуралдаанаар тусгай зөвшөөрлийн тухай (ТЗ шинээр олгох, сэргээх, хугацаа сунгах, түдгэлзүүлэх, хүчингүй болгох тухай) холбогдох газар, хэлтсийн боловсруулсан танилцуулга, үнэлгээний дүгнэлт бүхий 5 тогтоолын төслийг хавсралтын хамт тус тус хэлэлцээд, тус хуралдаанаас 5 тогтоолыг хавсралтын хамт батлан шийдвэрлэсэн. Үүнд:

- Зөвшөөрлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, 5.3 дугаар зүйлийн 1 дэх заалт, 8.1 дүгээр зүйлийн 9 дэх хэсгийн 9.12 дугаар заалт, Харилцаа холбооны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсэг, 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь заалт, 12 дугаар зүйлийн 12.1, Радио долгионы тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2.1 дэх

зүйлийг тус тус үндэслэн 2023 оны 03 дугаар сарын 17-ны өдрийн 25 тоот тогтоолын хавсралтаар 5 хуулийн этгээдэд 5 тусгай зөвшөөрлийг шинээр олгосон;

- Зөвшөөрлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, 6 дугаар зүйлийн 6.1.5 дахь заалт, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2, Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2 дахь заалтыг тус тус үндэслэн 2023 оны 03 дугаар сарын 17-ны өдрийн 26 тоот тогтоолын хавсралтаар 9 хуулийн этгээдийн 9 тусгай зөвшөөрлийг сэргээсэн;
- Зөвшөөрлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, 5.5 дугаар зүйл, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2, Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.3, Радио долгионы тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.3 дахь заалтыг тус тус үндэслэн 2023 оны 03 дугаар сарын 17-ны өдрийн 27 тоот тогтоолын хавсралтаар 9 хуулийн этгээдийн 9 тусгай зөвшөөрлийг сунгасан;
- Зөвшөөрлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 1.1 дэх заалт, 6.1 дүгээр зүйлийн 1.3 дахь заалт, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь заалт, Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн 2023 оны 03 дугаар сарын 17-ны өдрийн 28 тоот тогтоолын хавсралтаар 2 хуулийн этгээдийн 4 тусгай зөвшөөрлийг 45 хоногийн хугацаагаар түдгэлзүүлсэн;
- Зөвшөөрлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, 6.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2, Шуудангийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.4 дэх заалтыг тус тус үндэслэн 2023 оны 03 дугаар сарын 17-ны өдрийн 29 тоот тогтоолын хавсралтаар 2 хуулийн этгээдийн 4 тусгай зөвшөөрлийг хүчингүй болгон тус тус шийдвэрлэв.

Хуралдааны баталсан тогтоолын жагсаалт, холбогдох хавсралтыг <http://www.crc.gov.mn/main.php?cid=1&do=70&did=0> үзнэ үү).

Харилцаа холбооны зохицуулах хороо
2023-03-24